



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

116 /116/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.08.19

ИНЖЕНЕРИЙН ЦЭРЭГ ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ ТҮҮХТ 77 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ ХҮРГЬЕ!

МЭНДЧИЛГЭЭ

Эзэн Чингис хаан туурга тусгаар Их Монгол улс байгуулж дэлхийн талыг морин дэл дээр тамгалж, олон улс аймгийг нэгтгэн суу алдраа мандуулж, хүчирхэгжсэн нь монгол цэргийн алдар гавьяатай салшгүй холбоотой. Түүхэн цаг үеийнхээ явцад цэргийн урлаг шинэ шатанд хөгжин дэвжсээр дайн тулаанд оролцох, занга, зараа саад бэлтгэх, дайснаас хамгаалах бэхлэлт босгох зэргээр цэргийн урлаг, ахуй амьдралын хэв маягаас инженерийн цэргийн үүсэл тавигдсан.

Ардын хувьсгал ялснаар тухайн үеийн төр, нам засгийн бодлогын дагуу бүх ард түмнийг сайн сайхан амьдрах орчин нөхцөлийг сайжруулах бүтээн байгуулалт өрнөж барилга байгууламж барих, зам тавих, улс эх орныхоо хөгжил дэвшилд хөтлөхөд Ардын Армийн

гүйцэтгэх үүргийг тодорхойлсноор инженерийн цэргийн хэрэгцээ шаардлагатайг харуулсан юм. Үүнээс үндэслэн орчин цагийн Зэвсэгт хүчинд Цэргийн явдлын яамны сайд, Бүх цэргийн жанжны 1944 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн N/0112 дугаар тушаалаар "Ардын Армийн Салбарын тусгай рот" нэртэйгээр анхны инженерийн салбар байгуулагдсанаар Зэвсэгт хүчин хэмээх их айлд Инженерийн цэрэг анх үүссэн түүхтэй.

Монгол Улсын Зэвсэгт хүчний Инженерийн цэрэг нь үүсэн байгуулагдсан цагаасаа Зэвсэгт хүчний чиг үүргүүдийг гүйцэтгэхээс гадна улс орны энх цагийн бүтээн байгуулалтын тэргүүн эгнээнд манлайлан оролцож, монгол цэргийн түүхэн уламжлалыг залгамжилж, өмнөө

тавигдсан эрхэм үүргээ нэр төртэй биелүүлэхийн зэрэгцээ даян дэлхийн энхийн үйлсэд хүчин зүтгэж эх орон, Зэвсэгт хүчнийхээ нэр хүндийг өндөрт өргөхөд ихээхэн хувь нэмэр оруулан ажиллаж байна. Одоо үед Инженерийн цэрэг орчин үеийн техник хэрэгслээр шат дараатайгаар хангагдахын хэрээр гүйцэтгэх үүргийн цар хүрээ өргөжин тэлж, оюун ухаан, инженерийн нарийн шийдэл бүхий ажлуудыг амжилттай биелүүлж байгааг дурдах нь зүйтэй.

Инженерийн цэргийн түүхийг бичилцсэн үе үеийн ахмад дайчид, одоо ажиллаж байгаа эрхэм та бүхэндээ Инженерийн цэрэг үүсэн байгуулагдсаны түүхт 77 жилийн ойн баярын мэндийг хүргэж, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



БУРХАН ХҮНИЙГ БҮТЭЭСЭН БУСДЫГ НЬ ИНЖЕНЕРҮҮД БҮТЭЭСЭН
ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Б.АМГАЛАНБААТАР

ҮЙЛ ЯВДАЛ

ЕРӨНХИЙ КОНСУЛ Ч.ГАНБОЛД БРИГАДЫН ГЕНЕРАЛ С.ДАШЗЭВЭГИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Олон улсыг "Аравт" морин цэргийн уралдааны багийг ахалж яваа Зэвсэгт хүчний Жанжин штабын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг өчигдөр Монгол Улсаас ОХУ-ын Тува Улсад суугаа Ерөнхий консул Ч.Ганболдтой ажлын уулзалт хийлээ.

Уулзалтын үеэр бригадын генерал С.Дашзэвэг ОХУ-ын Батлан хамгаалах яамнаас зохион байгуулдаг Цэргийн наадамд оролцож буй Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчид болон "Аравт" морин цэргийн уралдаан, "Цэргийн ралли" тэмцээний бэлтгэл болон зохион байгуулалтын талаар харилцан ярилцлаа. Мөн тус хотноо байрлах

ОХУ-ын Еерөнхийлөгчийн нэрэмжит Кадетийн сургуулийн захирал Ондар Уранкыс Сергеевнаг хүлээн авч уулзав. Уулзалтын эхэнд Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын мэндчилгээг уламжилсан бөгөөд 2021-2022 оны сургуулийн жилд сонсгогч сурагчдыг хүлээн авч суралцуулах чиглэлээр ҮБХИС-ийн "Тэмүүжин өрлөг" сургуульд сурагч оюутан гаргах тал дээр харилцан ярилцаж уг сургуулийн материаллаг бааз болон сурах орчныг судлах туршуулын бүлгийг хүлээн авахад ҮБХИС-ийн удирдлага бэлэн байгааг мэдэгдэж цаашид хамтран ажиллах талаар санал бодлоо хуваалцлаа.

"УАДХЦ-МИНИЙ МЭРГЭЖИЛ" ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн өдрийг угтан агаарын цэргийн алба хаагчдын оюуны сэтгэлгээг хөгжүүлэх, мэргэжлийн бахархлыг нэмэгдүүлэх, монгол хэлний утга найруулга, цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилготойгоор зохион байгуулсан эсээ бичлэгийн уралдааны шилдгүүд тодорлоо. Энэ сарын 2-11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан тус эсээ бичлэгийн уралдаанд нийт 150 гаруй бүтээл ирснээс тэргүүн байрт Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн радиоэлектрони тэмцлийн офицер, ахмад Ө.Энхсаруул, дэд байрт Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн, бичээч-оператор У.Хонгорзул, гуравдугаар байрт Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн

зангилгааны дарга, холбооны инженер, ахмад Ц.Одгэрэл нарын бүтээлүүд шалгарсан юм.

Шагналыг өчигдөр Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа Б.Энхзоргол шүүгчдийн хамт гардуулан өглөө. Тэрээр энэ үеэр "Агаарын цэргээр овоглогддог хэн бүхний бахархалыг төрүүлсэн, мэргэжлийн онцлог, туршлага, хамт олноороо бахархах сэдэл өгсөн олон сайхан эсээ бичлэгүүд ирсэн. Өгөгдсөн сэдвийн хүрээнд бодит баримтад үндэслэн жишээ татсан, үйл явдлын шалтгаан, учир холбогдлыг ойлгомжтой, тодорхой байдлаар тайлбарласан нь ихээхэн олзуурхууштай байлаа" гэв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
15	4

ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
31	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.848.0	2.851.0
EUR	3.365.0	3.373.0
CNY	440.0	441.3
RUB	38.00	39.10
JPY	25.68	26.12
KRW	2.39	2.48

ЗУРХАЙ

2021.08.19 ПҮРЭВ ГАРАГ
/БИЛГИЙН ТООЛЛЫН 12/

НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ
САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ
ШАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:
Өвчин эмгэг ирнэ
Наран ургах, шингэх:
05:53-19:59
Барилдлага:
Үл зохилдох
Шүтэн барилдлага:
Хүрэлцэхүй
Суудал:
Хий

Энэ өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагй хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой.

Эл өдөр андагй тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн.

Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнзэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанвал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 187,532 +1582	ЭДГЭРСЭН 172,024 +1879	НАС БАРСАН 889 +5
-----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4384 +80	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 168 +9	ЭДГЭРСЭН 4131 +10
-----------------------------	-------------------------------	----------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 210,059,768
Эдгэрсэн Нийт: 188,189,688
Нас барсан Нийт: 4,404,266

МОГОЯД ХАЗУУСАН ҮЕД АВАХ АНХЫН ТУСЛАМК

УЛСЫГ АГААРЫН ДОВТОЛГООНООС ХАМГААЛАХ ЦЭРГИЙН ӨДРИЙГ УГТАН АГААРЫН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНД ТЭРГҮҮН, ДЭД БАЙРУУДАД ШАЛГАРСАН БҮТЭЭЛҮҮДИЙГ ТОЛИЛУУЛЖ БАЙНА.

Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн, радиоэлектрони тэмцлийн офицер, ахмад Ө.ЭНХСАРУУЛ

“УЛСЫГ АГААРЫН ДОВТОЛГООНООС ХАМГААЛАХ ЦЭРЭГ-МИНИЙ МЭРГЭЖИЛ”



Монгол Улсын эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийн хэлхээст түүх нь монгол цэргийн түүхтэй салшгүй холбоотой. Эртний Хүннү улс болоод Эзэн Чингисийн эрэлхэг баатрууд, Манжийн дарлалыг эсэргүүцсэн ард түмний тэмцэл, хөдөлгөөн, тусгаар тогтнолоо дэлхий дахинаа тунхаглан зарласан Ардын хувьсгал, газар нутгийнхаа халдашгүй дархан байдлыг хамгаалан дайсан Халхын голын болон Чөлөөлөх дайны түүхэн ялалт, эх орныхоо энх цагийн бүтээн байгуулалт, даян дэлхийн энхийн үйлсэд оруулж байгаа хувь нэмэр нь Монгол Улсын цэрэг армийн түүхийн нэгээхэн хэсэг билээ.

Энэхүү түүхийн эд эс нь болон хөгжиж, шинэчлэгдсээр ирсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний нэгээхэн хэсэг бол үеийн өвөг дээдсийн, бидний, миний мэргэжил болох “УЛСЫГ АГААРЫН ДОВТОЛГООНООС ХАМГААЛАХ ЦЭРЭГ” буюу одоогийн нэршил нь Зэвсэгт хүчний Агаарын цэрэг юм.

1960-аад оны үеэс эхлэн тухайн үеийн нам, төрийн удирдлагын зүгээс Монголын Ардын Армийн анги, салбаруудыг өргөтгөн зохион байгуулах, шинэ зэвсэглэл техник, боловсон хүчнээр хангахад чиглэгдсэн дэс дараатай арга хэмжээүүдийг авч хэрэгжүүлж эхэлсэн юм.

Энэ ажлын хүрээнд зөвхөн пуужин, радиотехникийн анхны анги, салбарууд байгуулагдсан нь өнөөгийн Зэвсэгт хүчний төрлийн цэрэг болох Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн үндэс суурь болсон түүхтэй.

Зэвсэгт хүчний түүхэн хөгжил болгонд Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэрэг нь үе үеийн ахмад дайчдын нөр их хөдөлмөрөөр өнөөгийн шинэчлэлд хүрснийг цохон тэмдэглэх нь зүйтэй болно.

Миний хувьд, өөрийн хэмжээнд уншиж судалснаар Агаарын довтолгооноос хамгаалах цэрэг буюу одоогийн Агаарын цэргийн хөгжлийн үеийг 4 үе шатанд хуваан авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- 1960-1974 он. Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн үндэс суурь нь тавигдаж байсан түүхэн он жилүүд. Энэхүү түүхэн жилүүдэд тодоос тод нэрээ мөнхөлсөн хүндэт төлөөлөгч бол Монголын Ардын Армийн шинэ төрлийн цэрэг болох Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн тулганы чулууг тулалцсан Монголын төр, цэргийн нэрт зүтгэлтэн, дэслэгч генерал Чойндогийн Пүрэвдорж мөн. Энэ эрхэм хүний оруулсан хувь нэмэр, хичээл зүтгэлд үе үеийн Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн бие бүрэлдэхүүн баярлаад баршгүй билээ.

- 1977-2000 он. Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн анги, салбарууд хороо болон өргөжиж байсан он жилүүд. 1990-

ээд оноос Төр засгаас Монголын Ардын Армийн зарим анги, салбарыг нэгтгэх, татан буулгах, Улсыг болон цэргийг агаарын довтолгооноос хамгаалах, тагнуул, холбооны зарим анги, салбарын мэргэжлийн болгон бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

- 2000-2017 он. Зөвхөн пуужингийн хороог нийслэлийн Налайх дүүрэгт дахин шинээр байгуулсан түүхэн жилүүд. Үүнийг дагаад ажлын байр нэмэгдэж Агаарын довтолгооноос хамгаалах цэрэг бүл нэмсэн он жилүүд юм. Мөн радиотелеграфчин, планшетчин гэх мэт тусгай бага мэргэжилтнүүдийн дамжааг хичээллүүлэн өөрсдийн нөөц бололцоогоор чадварлаг боловсон хүчин бэлтгэж эхэлсэн байдаг. 2005 оноос Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд идэвхтэй хамрагдан оролцож, Африкийн халуун цэгт үүргээ амжилттай гүйцэтгэж байсан.

- 2017-2021 он. Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Монгол Улсын Зэвсэгт хүчин нь Хуурай замын цэрэг, Агаарын цэрэг, Барилга-инженерийн цэрэг, Кибер аюулгүй байдлын цэрэг болон Тусгай хүчний цэргээс бүрдэхээр хуульчлагдсан. Өнөөдөр Монгол Улсын Агаарын цэрэг эрчимтэй хөгжлийнхөө үе шат руу ороод байна. Энэ том газар нутгийн аюулгүй байдлыг хангахад бие даасан Агаарын цэргийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах төрлийн цэргийн командлалтай болтлоо өргөжин хөгжсөн түүхэн жилүүд.

Монгол Улсын агаарын хяналтыг цоо шинэ шатанд гаргахаар 23 жилийн дараа буюу 100 жилийн түүхэн ойтойгоо зоглох тэр цаг үед Агаарын цэрэг нь тавьсан зорилгодоо хүрч, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий зэвсэглэл техниктэй болохын төлөө ахмад дайчдаас эхлээд өнөөдрийн ажиллаж байгаа бие бүрэлдэхүүн, түүнчлэн ажлын гараагаа дөнгөж эхэлж буй залуу хойч үеийнхэн маань хүчин зүтгэж, ирээдүйн хөгжилд хувь нэмрээ харамгүй оруулсаар байна.

Бид Зэвсэгт хүчнийхээ зэвсэглэл, техникийг шинэчлэх талаар санаачилга гарган дотооддоо бүтээх, турших, үйлдвэрлэх бодлогыг баримталсны үндсэн дээр Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Шинжлэх ухаан технологийн зөвлөл, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй сүүлийн 10 гаруй жил хамтран ажиллаж, багагүй эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бүтээл гаргалаа. Энэхүү ажлын үр дүнд өнгөрсөн жилээс өөрсдийн хүч, бололцоогоор цэргийн зориулалттай техник, хэрэгсэл зохион бүтээх, үйлдвэрлэх, сэргээн сайжруулалтын шинэ чанартай ажлуудыг хийж эхэлсэн. Тухайлбал, манай Зэвсэгт хүчний

залуу инженерүүд анхны дрон, нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг хийсэн. Гадаадад боловсрол эзэмшсэн манай цэргийн алба хаагчдын бүтээлүүд нь Оюуны өмчийн газар, цэргийн шинжлэх ухаан, технологийн зөвлөл, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэгдэн албан ёсны патент авсан нь цөөнгүй билээ.

Үүнээс үзэхэд Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн 4 үеийн түүхийн хэлхээнд тасралтгүй хөгжиж, бусдыгаа түүчээлэн үлгэр дуурайл болж, эргэн харахад амжилт дүүрэн он жилүүдийг ардаа үдсэн байна.

Ахмад дайчид, алба хаагчдын энэхүү албандаа оруулсан хувь нэмрийг төр засгаас үнэлж, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн үе үеийн цэргийн алба хаагчдын алдар гавьяаг мөнхжүүлэх, залуу хойч үеийг эх оронч үзлээр хүмүүжүүлэх, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн үйл ажиллагааг сурталчлах, хөгжүүлэх зорилгоор Батлан хамгаалахын сайдын 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 368 тоот тушаалаар жил бүрийн 8 дугаар сарын 11-ний өдрийг Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн өдөр болгон тэмдэглэж ирсэн. Тодруулбал, түүхийн хуудснаа 1964 оны 8 дугаар сарын 11-ний өдөр Ардын цэргийн хэрэг эрхлэх яамны сайд бөгөөд командлагчийн тушаалаар Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн анхны “Армийн радиотехникийн цэргийн батальон” байгуулагдаж 24 цагийн “байлдааны жижүүрлэлт”-ийн үүргээ гүйцэтгэж эхэлсэн билээ.

Энэ өдөр нь эх орноо батлан хамгаалах нэр хүндтэй, хариуцлагатай, ариун журамт үүргийг биелүүлж яваа цэргийн алба хаагчдын төдийгүй монгол түмний бахархалт баарын өдөр бөгөөд улс орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард түмнийхээ эрх чөлөөг хамгаалан тэмцсэн түүх, үе үеийн эх орончид, цэрэг дайчдынхаа гавьяат үйлсээр бахархах, хүүхэд, залууст цэрэг-эх оронч хүмүүжлийг олоход дэмжлэг үзүүлэхэд онцгой ач холбогдолтой.

Монгол Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэрэг эрс маань өнгөрсөн зуунаас эдүгээ түүчээлэн улс орноо батлан хамгаалах нэн хариуцлагатай бөгөөд нэр хүндтэй үүргийг амжилттай гүйцэтгэж, эх орныхоо нэр хүндийг олон улсын тавцнаа дурсган эх дэлхийн энх тайван, амар амгаланг тогтоох үйлсэд эр зориг, тэсвэр тэвчээр, мэргэжлийн ур чадвараа гайхуулан байна.

Миний бие цэрэг хүн болсондоо, тодруулан хэлбэл Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргээр овоглож байгаадаа баярлаж, ахмад дайчдаа хүндлэн, тэдний босгосон баганыг ганхуулахгүйн тулд үе тэнгийн нөхдийн хамтаар улам сайжруулан босгож байх болно гэдгийг бахдалтайгаар тангараглаж байна. Олон зууны баялаг түүх, орчин үеийн шинэ шинэ ололт амжилтаар Монгол Улсын цэрэг армийн түүхийн хуудсаа зузаатган, хөгжин бэхжиж байгаа Зэвсэгт хүчний Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн яруу алдар өнө мөнхөд мандан бадрах болтугай.

БИ УАДХЦ-ЭЭР ОВОГЛОСОН ААВЫН ОХИН БИ ТАНГАРАГ ӨРГӨСӨН ЦЭРГИЙН ХҮН БИД АГААРЫН ЦЭРГИЙН ЭД ЭС

Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн бичээч-оператор У.ХОНГОРЗУЛ

“УЛСЫГ АГААРЫН ДОВТОЛГООНООС ХАМГААЛАХ ЦЭРЭГ-МИНИЙ МЭРГЭЖИЛ”



Аливаа юм бүхэн өөрийн гэсэн онцлог агуулга, түүхтэй байдгийн дээр түүх болгон өнгөрснийг өгүүлж, бас сургамж дагуулж байдаг билээ.

БНМАУ-ын төр, засаг 1960-аад оны дунд үеэс Ардын цэргийг Ардын Арми болгон бэхжүүлэх, улмаар Монголын Улсын Зэвсэгт хүчнийг байгуулах зорилтуудыг дэвшүүлж, энэ ажил үргэлжилсээр бидний одоогийн ажиллаж, үр шимийг нь хүртэж, аж амьдралаа залгуулдаг өнөр өтгөн гэр бүл бий болсон билээ.

Цэрэг хүн нь хүч чадлаа эх орноо гэсэн сэтгэл зүрхэндээ, эрх мэдлээ мөрөн дээрх мөрддөгөө шингээсэн маш хүнд хариуцлага хүлээсэн дайчид юм. Үүнийг бусад мэргэжлийн хариуцлагатай харьцуулах аргагүй билээ.

Би өдөр, шөнөгүй онгоц, нисдэг тэрэг, армийн дүрэмт хувцастай ах эгч нарыг харж өссөн болоод ч тэр үү цэргийн ангид ажиллахыг мөрөөддөг байж билээ. Одоо би өглөө бүр төрийн дуулал нь эгшиглэхүй дор жагсаалын алхаагаар алхах хийморьлог цэрэг эрсийг харж, тэд нараараа бахархаж явдаг юм.

Би өөрийгөө энгийн нэгэн ажилтан миний ажил тийм ч чухал үүрэгтэй биш гэж боддог байлаа.

Гүн ухаантан Сенека хэлэхдээ “Аль зогсоол уруу хөвж яваагаа мэдэхгүй хөлөг онгоцны дарвуулыг ямар ч салхи үлээгээд нэмэргүй” гэж хэлсэн байдаг. Үүнийг сонсоод бид нэг командлагчаар удирдуулж, нэг зүг рүү харж, нэгэн зэрэг хүчээ дайчлах ёстой юм байна гэж бодсон. Энгийн, цэргийн гэлтгүй зорилтуудыг дэвшүүлж, энэ ажил үргэлжилсээр бидний одоогийн ажиллаж, үр шимийг нь хүртэж, аж амьдралаа залгуулдаг өнөр өтгөн гэр бүл бий болсон юм.

Хүн бүр өөрөөр сэтгэх нь дамжиггүй боловч Монголын бахархал гэдэг өнгөрсөн, одоо, ирээдүй аль ч цаг хугацааны мөчлөгт монгол цэрэг байсан, одоо ч байгаа, цаашид ч байх болно гэж би боддог.

Нэгэн монгол цэргийг Иракт үүрэг гүйцэтгэж байх үест бид бүхэн Чарли хотын эртний Бабилоныг үзэж явахад нь нэгэн арслангийн хөшөө толгойгүй байсны учрыг асуухад тайлбарлагч эмэгтэй танай өвөг дээдэс энд ирж арслангийн толгойг цавчсан юм гэж хэлсэн гэдэг. Хэдийгээр арслангийн хөшөөний толгойг цавчсан нь түүхийн бодит гэрч боловч өвөг дээдэс маань энэ хол газрыг хэрхэн туулж, цаг агаарын эрс тэс өөр орчинд яаж дасан зохицож, гайхамшигтайгаар цэрэглэж чадаж байсныг бодоход өөрийн эрхгүй цэрэг эрсээрээ бахархах сэтгэл төрж байна.

Өнөөдөр монгол цэргийн гадаад харилцаа

ихээхэн өргөн дэлгэр болж Орос, Хятад, АНУ, Солонгос, Япон, Герман, Канад зэрэг дэлхийд цэргийн хөгжлөөрөө тэргүүлж байгаа улс оронд Монголын офицер, ахлагч нар бусад орны офицер, ахлагч нартай мөр зэрэгцэн сурч, ажиллаж байна.

Миний бодлоор Зэвсэгт хүчинд бэлтгэгдсэн шинэ боловсон хүчний ажлын байр, зэвсэглэл, техник дутмаг зарим техник нь бүр байхгүй, одоогийн байгаа техник хэрэгсэл шинэчлэл хийгдээгүй, 1970-1980 оны автотехникүүдээр өнөөгийн 21 зуунд үүргээ гүйцэтгэсэн хэвээрээ байгаа нь нөгөө талаар эдийн засгийн болон тавигдах шаардлагад нийцэхгүй байгаа юм.

Тиймд Монгол Улс, Засгийн газар Батлан хамгаалах салбартаа тулхуу анхаарч одоо олгогдож байгаа төсвөө 2-3 дахин нэмж, гаднын улс орны бүтээгдэхүүнийг экспортлохоосоо илүү улсдаа хийж чадварлаг боловсон хүчнийг бэлтгэж, бүтээдэг, үйлдвэрлэдэг инженер, техникч, баг, хамт олныг бүрдүүлж ажиллах хэрэгтэй гэж би боддог. Мөн техник, технологи, социал орчин хөгжиж байгаа энэ цаг үед бид Зэвсэгт хүчний талаарх олон шинэлэг зүйлийг санаачилж, уриалж иргэн-цэргийн харилцаагаа бэхжүүлэх ажлуудыг явуулах зүйтэй. Бид чадна!

Магадгүй үүнийг уншиж буй бүсгүй эсвэл залуу та дөнгөж өнөөдөр цолоо зүүгээд ирж буй шинэхэн дэслэгчийн гэргий эсвэл нөхөр бол дөрвөн зүгтээ эх орноо хамгаалах тангараг өргөсөн ахлагчийн хань бол дөрөө нийлүүлэх амьдралын замд ханьтайгаа анхлан учирч, улс орноо хамгаалж, элэг бүтэн, энх жаргалтай гэр бүлийнхээ төлөө сонгосон мэргэжил, хүссэн ажил, хүсэл мөрөөдлийг нь хүндэлж, бахархаж яваарай.

ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ БАГИЙН АЛБАН ХААГЧДЫГ ВАКЦИНЫ III ТУНД ХАМРУУЛЖ ЭХЭЛЛЭЭ



“Ковид-19” цар тахлын эсрэг тэргүүн эгнээнд ажиллаж буй Хариу арга хэмжээний багийн ажилтан, албан хаагчдад АстраЗенека вакцины гурав дахь тунг сайн дурын үндсэн дээр хийнэ.

АстраЗенека вакцины хоёр тунг хийлгэсэн бол гуравдугаар тунд дархлаа өндөр тогтож буй олон улсын судалгаа гарчээ.

Харин иргэдэд нэмэлт буюу гурав дахь тунг хийх эсэх талаарх эцсийн шийд гараагүй, судлагдаж байна. Учир нь вакцинууд өөр тул нарийвчилсан судалгаа хийж байгаа гэнэ. Мөн нэмэлт тунг вакцинд хамрагдсанаас хойш зургаан сарын дараа хийлгэх нь илүү үр дүнтэй гэж олон улсын судлаачид үзжээ.